

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Ж.ГАН-ЭРДЭНЭ
ТАНАА

2021.02.25 № 07/474

танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Боловсролын үнэлгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах”, “Монгол хэл бичгийн шалгалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах”, “Улсын шалгалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах”, “Боловсролын чанарын үнэлгээний судалгааг үндэсний хэмжээнд зохион, бүх шатны боловсролын чанарын үнэлгээний чиглэлээр шалгалт, судалгаа зохион байгуулах”, “Төсөл хөтөлбөр боловсруулах, нээлттэй даалгаврын санг хөгжүүлэх хэрэгжүүлэх”, “Мэдээлэл, сурталчилгаа, сургалт, үнэлгээ хийх”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийг хөгжүүлэх” 9 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсөв захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,233,146,227.02	413,895,612.13
33	АВЛАГА	1,130,518,510.36	271,369,473.79
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	7,706,895.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,123,219,523.93	247,260,841.70
335	Бусад авлага	7,298,986.43	16,401,737.09
3351	Байгууллагаас авах авлага	1,671,301.43	15,122,677.09
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,627,685.00	1,279,060.00
35	БАРАА МАТЕРИАЛ	102,627,716.66	142,526,138.34
351	Түүхий эд материал	17,381,800.00	44,528,621.68
35110	Тусгай зориулалттай материал	17,381,800.00	44,348,621.68
35130	Эм боох материал	00.00	180,000.00
354	Хангамжийн материал	85,245,916.66	97,997,516.66
35410	Бичиг хэргийн материал	24,400,316.66	22,758,966.66
35420	Аж ахуйн материал	15,478,000.00	25,035,500.00
35440	Түлш, шатах тослох материал	2,484,000.00	3,843,950.00
35470	Бусад хангамжийн материал	42,883,600.00	46,359,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,583,579,360.23	1,289,011,069.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,583,579,360.23	1,289,011,069.85
392	Биет хөрөнгө	1,536,376,526.58	1,219,053,030.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,629,400.00	24,375,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(65,629,400.00)	(7,447,916.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,430,672,094.00	2,557,754,844.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,008,457,146.76)	(1,432,961,343.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,300,760.33	93,441,993.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,957,930.96)	(26,553,296.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	52,884,840.00	52,884,840.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,066,090.03)	(42,441,090.07)
393	Биет бус хөрөнгө	47,202,833.65	69,958,039.12
39301	Программ хангамж	296,324,560.00	347,603,560.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(249,121,726.35)	(277,645,520.88)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,816,725,587.25	1,702,906,681.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.26	11,570,858.61
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.26	11,570,858.61
413	Өглөг	00.26	11,570,858.61
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.26	2,812,578.61
4136	Бусад өглөг	00.00	8,758,280.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,892,305.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	5,865,975.00
42113	Бондын хөнгөлөлт	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,816,725,586.99	1,691,335,823.37
51	Засгийн газрын хувь оролцоо	2,816,725,586.99	1,691,335,823.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	344,839,013.00	344,839,013.00
51101	Өмч: - төрийн	344,839,013.00	344,839,013.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,471,728,389.56	1,346,496,810.37
51210	Өмнөх үеийн үр дүн	2,471,728,389.56	2,471,886,573.99
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(1,125,389,763.62)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,816,725,587.25	1,702,906,681.98

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,759,574,047.00	2,507,485,661.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,429,096,057.00	628,018,949.79
120	Нийтлэг татварын бус орлого	1,429,092,057.00	628,018,949.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,427,075,417.00	627,510,528.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	346,582,069.00	603,135,528.11
1200042	слах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,720,000.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,077,773,348.00	24,375,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	2,016,640.00	508,421.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,330,477,990.00	1,879,466,712.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,564,224,400.00	1,345,380,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,564,224,400.00	1,345,380,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,766,253,590.00	534,085,912.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	226,975,360.00	262,931,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,539,278,230.00	271,154,212.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,921,259,311.81	3,632,875,425.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,921,259,311.81	3,632,875,425.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,869,656,530.25	3,600,507,750.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	902,585,031.69	1,382,924,134.60
210101	Үндсэн цалин	504,518,669.00	542,864,905.00
210102	Нэмэгдэл	145,015.00	86,273.00
210105	Гэрээт ажлын хөлс	397,921,347.69	839,972,956.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,919,816.88	175,828,649.54
210201	Тэтгэврийн даатгал	91,902,454.68	153,746,636.34
210202	Тэтгэмжийн даатгал	5,066,740.80	5,696,902.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,986,831.44	4,893,095.18
210204	Ажилгүйдлийн даатгал	996,709.36	1,092,340.36
210205	Эрүүл мэндийн даатгал	9,967,080.60	10,399,674.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,800,000.00	138,722,400.00
210304	Байрны түрээс	91,800,000.00	138,722,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	101,888,659.45	69,415,778.60
210401	Бичиг хэрэг	73,129,190.00	33,168,650.00
210402	Тээвэр, шатахуун	15,499,527.00	9,838,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,770,442.45	6,416,528.60
210404	Ном, хэвлэл	00.00	14,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,489,500.00	5,991,950.00
2105	Норматив зардал	00.00	51,418,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	51,418,000.00
2107	Томилолт, зочны зардал	40,091,840.00	82,932,600.00

210701	Гадаад албан томилолт	00.00	38,166,000.00
210702	Дотоод албан томилолт	40,091,840.00	44,766,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,543,163.08	113,922,734.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,444,029.08	13,042,164.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,474,934.00	2,416,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,000.00	252,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,781,400.00	3,669,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,665,800.00	94,542,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,540,828,019.15	1,585,343,454.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,076,299,271.24	1,057,006,163.67
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	464,528,747.91	528,337,290.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,602,781.56	32,367,674.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,402,781.56	32,367,674.62
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	32,367,674.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,356,563.06	00.00
	Хөрөнгийн	8,046,218.50	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,838,314,735.19</u>	<u>(1,125,389,763.62)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,838,314,735.19</u>	<u>(1,125,389,763.62)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,679,780,059.00</u>	<u>3,610,170,389.04</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	349,302,069.00	607,484,153.11
120	Нийтлэг татварын бус орлого	349,302,069.00	607,484,153.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	349,302,069.00	607,484,153.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	346,582,069.00	607,484,153.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,720,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,330,477,990.00	3,002,686,235.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,564,224,400.00	1,345,380,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,564,224,400.00	1,345,380,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,766,253,590.00	1,657,305,435.93
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	226,975,360.00	262,931,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,539,278,230.00	1,394,373,735.93
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,614,430,059.00</u>	<u>3,400,776,389.04</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,614,430,059.00	3,400,776,389.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,439,607,753.51	3,121,147,872.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	731,490,007.81	1,392,156,028.69
210101	Үндсэн цалин	226,854,800.00	356,932,700.00
210102	Нэмэгдэл	74,453,960.12	115,015,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,259,900.00	57,090,416.07
210104	Урамшуулал	1,000,000.00	314,483.93
210105	Гэрээт ажлын хөлс	397,921,347.69	862,802,528.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,284,031.11	171,976,561.54
210201	Тэтгэврийн даатгал	77,193,162.88	157,065,161.54
210202	Тэтгэмжийн даатгал	3,336,300.00	3,727,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,224,000.00	2,982,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	414,568.88	745,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,115,999.35	7,455,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,800,000.00	138,722,400.00
210304	Байрны түрээс	91,800,000.00	138,722,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	96,569,229.45	47,467,778.60
210401	Бичиг хэрэг	68,173,000.00	13,179,950.00
210402	Тээвэр, шатахуун	14,833,287.00	7,704,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,770,442.45	6,416,528.60
210404	Ном, хэвлэл	00.00	14,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,792,500.00	6,167,200.00
2105	Нормативт зардал	00.00	51,598,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	51,598,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	5,277,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,210,000.00
210602	Тавилга	00.00	1,067,000.00
2107	Томилолт, зочны зардал	40,091,840.00	82,932,600.00
210701	Гадаад албан томилолт	00.00	38,166,000.00

210702	Дотоод албан томилолт	40,091,840.00	44,766,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	286,623,972.47	146,559,921.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	254,174,838.47	27,679,351.65
210803	Даатгалын үйлчилгээ	2,474,934.00	2,416,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,000.00	252,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,781,400.00	3,669,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	28,015,800.00	112,542,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,103,748,672.67	1,084,457,582.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,103,748,672.67	1,084,457,582.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,174,822,305.49	279,628,516.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,173,622,305.49	279,628,516.32
213301	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,356,563.06	32,367,674.62
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,131,265,742.43	247,260,841.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>65,350,000.00</u>	<u>209,394,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	65,350,000.00	209,394,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,350,000.00	209,394,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	65,350,000.00	209,394,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	65,350,000.00	209,394,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(65,350,000.00)</u>	<u>(209,394,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	591,363,648.63	936,360,846.06
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	591,363,648.63	936,360,846.06
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	105,385,061.73	105,385,061.73
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	2,471,728,389.56	2,816,725,586.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	158,184.43	158,184.43
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	2,471,886,573.99	2,816,883,771.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	(158,184.43)	00.00	(158,184.43)
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(1,125,389,763.62)	(1,125,389,763.62)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	00.00	1,346,496,810.37	1,691,335,823.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,948,517,000.00	1,920,497,278.49	(28,019,721.51)	98.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,948,517,000.00	1,920,497,278.49	(28,019,721.51)	98.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,948,025,000.00	1,920,497,278.49	(27,527,721.51)	98.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	529,353,500.00	529,353,500.00	0.00	100.0
Үндсэн цалин	356,932,700.00	356,932,700.00	00.00	100.00
Нэмэгдэл	115,015,900.00	115,015,900.00	00.00	100.00
Унаа хоолны хөнгөлөлт	56,404,900.00	57,090,416.07	685,516.07	101.22
Урамшуулал	1,000,000.00	314,483.93	(685,516.07)	31.45
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,653,600.00	66,653,600.00	0.00	100.0
Тэтгэврийн даатгал	51,742,200.00	51,742,200.00	00.00	100.00
Тэтгэмжийн даатгал	3,727,900.00	3,727,900.00	00.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	2,982,300.00	2,982,300.00	00.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	745,600.00	745,600.00	00.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	7,455,600.00	7,455,600.00	00.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,800,000.00	91,800,000.00	0.00	100.0
Байрны түрээс	91,800,000.00	91,800,000.00	00.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	23,825,900.00	23,209,178.60	(616,721.40)	97.4
Бичиг хэрэг	8,895,000.00	8,364,750.00	(530,250.00)	94.04
Тээвэр, шатахуун	6,143,900.00	6,143,900.00	00.00	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,503,000.00	6,416,528.60	(86,471.40)	98.67
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,284,000.00	2,284,000.00	00.00	100.00
Нормативт зардал	2,131,000.00	2,131,000.00	0.00	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,131,000.00	2,131,000.00	00.00	100.00
Томилолт, зочны зардал	20,819,700.00	20,819,700.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	20,819,700.00	20,819,700.00	00.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,629,400.00	143,683,717.65	(16,945,682.35)	89.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,999,800.00	24,803,147.65	(16,196,652.35)	60.50
Даатгалын үйлчилгээ	2,475,000.00	2,416,920.00	(58,080.00)	97.65
Тээврийн хэрэгслийн татвар	273,700.00	252,000.00	(21,700.00)	92.07
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,669,400.00	3,669,400.00	00.00	100.00

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	113,211,500.00	112,542,250.00	(669,250.00)	99.41
Бараа үйлчилгээний бусад зардал	1052811900.00	1042846582.24	(9,965,317.76)	99.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,052,811,900.00	1,042,846,582.24	(9,965,317.76)	99.05
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	492000.00	0.00	(492,000.00)	0.0
Бусад урсгал шилжүүлэг	492,000.00	00.00	(492,000.00)	0.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	492,000.00	00.00	(492,000.00)	00.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,948,517,000.00	1,920,497,278.49	(28,019,721.51)	98.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,345,380,800.00	1,313,013,125.38	(32,367,674.62)	97.6
Улсын төсвөөс санхүүжих	1,345,380,800.00	1,313,013,125.38	(32,367,674.62)	97.59
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	603,136,200.00	607,484,153.11	4,347,953.11	100.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	603,136,200.00	607,484,153.11	4,347,953.11	100.72
АЖИЛЛАГСАДЫН ТОО	38	38	0.0	
Удирдах ажилтан	1	1	0.0	
Гүйцэтгэх ажилтан	38	38	0.0	
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38	38	0.0	
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	38	38	0.0	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,657,305,435.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,657,305,435.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,410,044,594.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		862,802,528.69
210105	Гэрээт ажлын хөлс		862,802,528.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		105,322,961.54
210201	Тэтгэврийн даатгал		105,322,961.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		46,922,400.00
210304	Байрны түрээс		46,922,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал		24,258,600.00
210401	Бичиг хэрэг		4,815,200.00
210402	Тээвэр, шатахуун		1,560,200.00
210404	Ном, хэвлэл		14,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,883,200.00
2105	Нормативт зардал		49,467,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		49,467,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		131,466,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		121,500,000.00
210602	Тавилга		9,966,000.00
2107	Томилолт, зочны зардал		62,112,900.00
210701	Гадаад албан томилолт		38,166,000.00
210702	Дотоод албан томилолт		23,946,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,876,204.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,876,204.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		124,816,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		124,816,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		247,260,841.70
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		247,260,841.70
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,657,305,435.93
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,657,305,435.93
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		262,931,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,394,373,735.93
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Боловсролын үнэлгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Ж.Ган-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, НӨАТ-ын төлбөрийн цахим системд харилцагч байгууллагын и-баримтыг шивүүлэх, шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 25-наас 2021 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын Хоёрдугаар газрын аудитын менежер С.Нацагдорж анхан шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор Ч.Дашдаваа нар хариуцан гүйцэтгэв.

Боловсролын үнэлгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Боловсролын үнэлгээний төв нь сурлагын амжилт, бүх шатны боловсролын сургалтын чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ судалгаа хийх, сургалт зохион байгуулах, их дээд сургууль, коллежид элсэгчдээс авах ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын мэдлэг, чадварын түвшинг тогтоох зорилго бүхий элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх шатны сургалтын байгууллагын сургалтын чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын жишиг арга зүй, аргачлалаар боловсруулах, чанарын хяналт-шинжилгээ хийх, санал, дүгнэлт гаргах;
- Шалгуулагчдын дүн оноо ил тод, нээлттэй, шударга, шуурхай болох боломжийг бүрдүүлж, нийгэм, эдийн засгийн бодит үр дүнг бий болгох;
- Улсын шалгалтын жишиг даалгавар боловсруулж, сургуулиуд өөрсдийн хөтөлбөрт нийцүүлэн даалгавраа сонгодог, нууцлалаа хангадаг тогтолцоог бий болгосон;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай;

- Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай;
- Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор баталсан Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай;
- Засгийн газрын 2020 оны 98 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай;
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталсан Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай;
- Засгийн газрын 2020 оны 168 дугаар тогтоолоор баталсан Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай;
- Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор баталсан Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай;
- Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Боловсролын үнэлгээний төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 онд Боловсролын үнэлгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 12 зөвлөмж өгсөн байна.

БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас шилэн дансанд хийсэн дотоод аудитаар 83 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,921,259.3 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 58,425.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Боловсролын үнэлгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,113,818.9 мянган төгрөгөөр буюу 60.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1,130,518.5	271,369.5	(859,149.0)
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	102,627.7	142,526.1	39,898.4
Үндсэн хөрөнгө	1,583,579.4	1,289,011.1	(294,568.3)
Нийт хөрөнгө	2,816,725.6	1,702,906.7	(1,113,818.9)
Өр төлбөр	0.0	11,570.9	11,570.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,816,725.6	1,691,335.8	(1,125,389.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,816,725.6	1,702,906.7	(1,113,818.9)

Авлага дансны үлдэгдэл 271,369.5 мянган төгрөг болж 859,149.0 төгрөгөөр буурсан нь Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлагыг оны эхэнд буцаан авсанаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 142,526.1 мянган төгрөг болж 39,898.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,289,011.1 мянган төгрөг болж 294,568.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 33,826.0 мянган төгрөг, төслийн хөрөнгөөр 117,290.0 мянган төгрөг, төсөл хөтөлбөр арга хэмжээний хөрөнгөөр 8,899.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө акталсан 102,520.4 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 69,958.0 мянган төгрөг болж 22,755.2 мянган төгрөгөөр өссөн нь цахим хуудсыг харааны бэрхшээлтэй иргэд сонсох боломжтой болгох 49,379.0 мянган төгрөгийн программ хангамж нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 11,570.9 мянган төгрөг болж 11,570.9 мянган төгрөгөөр өссөн нь Ковид 19 цар тахлаас шалтгаалан боловсролын чанарын үнэлгээ, судалгааны шалгалт хойшлогдож, сэдэв, даалгавар зохиосон багш нарт олгох цалингийн өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,691,335.8 мянган төгрөг болж 1,125,389.8 мянган төгрөгөөр буурсан нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, элэгдлийн зардал, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй дээд боловсролын чанарын шинэчлэл төслийн татаас санхүүжилтийн авлагыг оны эхэнд авч төсөлд ажилласан гэрээт ажиллагсадын 2018 он, 2019 он, 2020 оны 1-4 сарын цалинг нөхөн олгосоноос шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,252,088.4 мянган төгрөгөөр буюу 52.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого байна. Энэ нь ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийн тоо анги дэвшин суралцсанаас шалтгаалан бага байснаас шалтгаалжээ. байна.

Нийт зардал өмнөх оноос 711,616.1 мянган төгрөгөөр буюу 24.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлууд байна. Дэлхийн банкны төсөл хэрэгжиж гэрээгээр ажиллагсдын цалингийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төслийг төлөвлөхдөө зардлыг санхүүжүүлэх нийт эх үүсвэрийг 3,149,408.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,149,408.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,200,891.8 мянган төгрөгийг бууруулж 1,948,517.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Дээд шатны байгууллагад хүргүүлсэн төсвийн төслийн саналаас 1,200,891.8 мянган төгрөгийг бууруулж баталсан мөн төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 279,628.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь төсвийн төлөвлөлт бодитой боловсруулаагүй байгааг харуулж байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,948,517.0 мянган төгрөгийн төсөв баталснаас, 1,345,380.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 603,136.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,345,380.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 607,484.2 мянган төгрөг, нийт 1,952,865.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,920,497.3 мянган төгрөгийг зарцуулж 32,367.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,920,497.3 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь бичиг хэргийн зардлыг 530.3 мянган төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 86.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлыг 16,196.7 мянган төгрөгөөр, улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх зардлыг 669.3 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 19,982.6 мянган төгрөг, гэрээт ажиллагсдын зардал арга хэмжээ 7,545.1 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал арга хэмжээ 492.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 3. Төсвийн зардлын гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	80101	Үндсэн үйл ажиллагаа	1,917,251.7	1,897,269.1	(19,982.6)	99.0
2	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	-	-	-	-
3	80221	Гэрээт ажиллагсдын зардал	30,773.2	23,228.1	(7,545.1)	75.5
4	80802	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	492.0	0	(492.0)	0.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гадаад төсөл хөтөлбөрөөс 1,123,219.5 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 262,931.7 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 271,154.2 мянга, нийт 1,657,305.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Гэрээт ажлын хөлсөнд 862,802.5 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 105,323.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 46,922.4 мянга, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэлд 49,467.0 мянга, эд хогшил худалдан авах зардалд 134,466.0 мянга, томилолтын зардалд 62,112.9 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжид 2,876.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 124,816.0 мянга нийт 1,410,044.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 247,260.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 81 мэдээлэл, хугацаа хоцроосон 24 мэдээлэл, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээлэлд DVD, хор, батарей худалдан авсан 8,233.0 мянга, албан томилолтын 19,043.7 мянга, нийт 27,276.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээнүүдийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 91,583.3 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 94.3 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган. төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	4	91,583.3	3	90,398.6	1	1,279.0	94.3
Нийт дүн	4	91,583.3	3	90,398.6	1	1,279.0	94.3

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 53,357.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,680.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 27,276.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 14,400.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Завсрын аудитаар 14,803.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тавьж, тайлангийн хугацаанд төлж барагдуулсан.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хувь хүний орлогын албан татварын илүү суутгасан 319.4 мянган төгрөгийн авлагыг Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланд залруулга хийлгэсэн.
2. Өр төлбөр дансны ерөнхий журналаарх дебет, кредит дүн өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл, ерөнхий дэвтрээс ажиллагчидтай холбогдсон өглөг 11,245.9 мянган төгрөгөөр, байгууллагад өгөх өглөг 115.4 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн бичилтийг залруулсан.
3. Завсрын аудитаар зардлын эдийн засгийн ангилал зөрүүлж тайлагнасан 58,889.4 мянган төгрөгийн 5 зөрчлийг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 42,079.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил илэрснээс 14,803.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 27,276.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгаа PISA 2021” төсөлд ажилласан 12 ажилтаны 2018, 2019, 2020 онуудад хийсэн ажлын хөлс 224,765.4 мянган төгрөгийн цалинг нөхөн тооцож олгохдоо 14,803.2 мянган төгрөгийн НДШ-ийг дутуу суутгасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”, 16 дугаар зүйлийн 16.1-д “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

- Байгууллагын цахим хуудасны бичвэр мэдээллийг харааны бэрхшээлтэй иргэд сонсох боломжтойгоор программчлах зорилгоор 2020 оны 01 сарын 14 өдөр байгуулсан “Зөвлөх үйлчилгээний гэрээ”-ний ажлын үр дүнтэй танилцахад ЕЕС.MN

цахим хуудас монгол хэлээр өгөгдлүүд уншигдахгүй, харааны бэрхшээлтэй шалгуулагчдад бусадтай адил цахим үйлчилгээг авах боломжийг хангаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, Зөвлөх үйлчилгээний гэрээний ажлын даалгаврын зорилго “Харааны бэрхшээлтэй шалгуулагчдад бусадтай адил цахим үйлчилгээг авах боломжийг олгох”, Зөвлөх үйлчилгээний гэрээний 6 дахь заалт “Зөвлөх нь гэрээгээр гүйцэтгэх зөвлөх үйлчилгээг бүрэн гүйцэтгэж 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Боловсролын үнэлгээний төвд хүлээлгэн өгнө” гэж заасан заалттай нийцэхгүй, оршин байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөх

Шилэн дансанд хуулиар байршуулах 4,074,953.3 мянган төгрөгийн гүйлгээнээс 27,276.7 мянган төгрөгийн DVD, принтерийн хор, батерей худалдан авсан болон албан томилолтын зарцуулалттай холбоотой 2 ажил гүйлгээг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” 6.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай нийцэхгүй, Иж бүрэн байх, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 14,400.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тус байгууллагын үндсэн ажилтнууд үндсэн цалингаас гадна төсөл хэрэгжүүлэх ажилд оролцож тайлант онд Дээд боловсролын чанарын шинэчлэл төслөөс 12 ажилтан 12,310.0 мянган төгрөг, Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгааны төслөөс 30 ажилтан 348,601.0 мянган төгрөгийн цалин, хөлс авсан ба нэг ажилтны дундаж цалин хөлс, тэдгээртэй адилтгах сарын орлого дунджаар 2209.4 мянган төгрөг байгааг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 13 нэр төрлийн 347,603.6 мянган төгрөгийн программ хамгамжийг ажиллаж буй программуудтай тулгалт хийж, тооллого хийсэн боловч эд хариуцагчийн картанд 2 ширхэг программ хангамжийг бүртгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгахгүй байх, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт сулрах

1.3. Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах

1.3.1. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2. *Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал*

2.1 Илрүүлэлт:

Тайлант онд нийт 1,165,092.1 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 149 аж ахуйн нэгж байгууллагуудын 777,135.3 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлбөрийн цахим системд шивэгдэж, 387,956.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийн цахим системд дутуу шивэгдсэн байна.

2.2 Эрсдэл:

Тухайн сард борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг албан татвар суутган төлөгч төсөвт төлөхгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Бараа ажил үйлчилгээ худалдан авах гүйлгээг и-баримтаар баталгаажуулж, Нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийн цахим системээр хяналт тавьж ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Боловсролын үнэлгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/42/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Боловсролын үнэлгээний төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын цахим хуудасны бичвэр мэдээллийг харааны бэрхшээлтэй иргэд сонсох боломжтойгоор програмчлах зорилгоор 2020 оны 01 сарын 14 өдөр байгуулсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ"-ний ажлын үр дүнтэй танилцахад ЕЕС.MN цахим хуудас монгол хэлээр өгөгдлүүд уншигдахгүй, харааны бэрхшээлтэй шалгуулагчдад бусадтай адил цахим үйлчилгээг авах боломжийг хангаагүй.		Албан шаардлага	Захирал, Захиргаа удирдлагын газрын дарга	Ж.Ган-Эрдэнэ Ш.Шижирэрдэнэ
2	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 13 нэр төрлийн 347,603.6 мянган төгрөгийн программ хангамжийн оны эцсийн үлдэгдэлд тооллого хийсэн боловч, эд хариуцагчийн картанд 2 ширхэг программыг бүртгээгүй.	14,400.0	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ Н.Шинэбаяр
3	Тайлант онд нийт 1,165,092.1 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 149 ААН-үүдийн 777,135.3 мянган төгрөгийн НӨАТ төлбөрийн цахим системд шивэгдэж, 387,956.8 мянган төгрөгөөр НӨАТ-ын төлбөрийн цахим системээс зөрүүтэй.		Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ Н.Шинэбаяр
4	Шилэн дансанд нийт 107 мэдээлэл оруулахаас хугацаандаа 81, хугацаа хоцроож 24, байршуулаагүй 2 мэдээлэл байна. Шилэн дансанд хуулиар байршуулах 4,074,953.3 мянган төгрөгийн гүйлгээнээс 27,276.7 мянган төгрөгийн DVD, хор, батарей худалдан авсан болон албан томилолтын зарцуулалттай холбоотой 2 ажил гүйлгээг байршуулаагүй.	27,276.7	Албан шаардлага	Захирал, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ Н.Шинэбаяр
5	Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгаа PISA 2021" төсөлд ажилласан 12 ажилтны 2018 он, 2019 он, 2020 оны 01-04 саруудын 224765.4 мянган төгрөгийн цалин хөлсийг тооцож олгохдоо 1,498.9 мянган төгрөгийн ХХОАТ-ыг илүү, 14,803.2 мянган төгрөгийн НДШ-ийг дутуу суутгасан.	14,803.2	Төлбөрийн акт	Захирал, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ Н.Шинэбаяр
ДҮН		56,479.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 24 № 10/АО170063
САГ-2021/42/СТА-ТшЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсролын үнэлгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Байгууллагын цахим хуудасны бичвэр мэдээллийг харааны бэрхшээлтэй иргэд сонсох боломжтойгоор програмчлах зорилгоор 2020 оны 01 сарын 09 өдөр "Ай Дейм" ХХК-тай байгуулсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ"-ний ажлын үр дүнтэй танилцахад ЕЕС.MN цахим хуудас монгол хэлээр өгөгдлүүд уншигдахгүй, харааны бэрхшээлтэй шалгуулагчдад бусадтай адил цахим үйлчилгээг авах боломжийг хангаагүй байна.
- Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", Зөвлөх үйлчилгээний гэрээний ерөнхий зүйлд заасан зорилго "Харааны бэрхшээлтэй шалгуулагчдад зориулан цахим үйлчилгээ /www.eec.mn/-г w3c стандартын дагуу шинэчилж дэлгэц уншдаг програм хангамжаар унших боломжтой болгон хөгжүүлж нэвтрүүлэх", Зөвлөх үйлчилгээний гэрээний 6 дахь заалт "Зөвлөх нь гэрээгээр гүйцэтгэх зөвлөх үйлчилгээг бүрэн гүйцэтгэж 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Боловсролын үнэлгээний төвд хүлээлгэн өгнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Харааны бэрхшээлтэй шалгуулагчдад цахим үйлчилгээ авах боломжийг хангаж, гэрээний үүргийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Боловсролын үнэлгээний төвийн захирал Ж.Ган-эрдэнэ, Захиргаа удирдлагын газрын дарга Ш.Шижир-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 06 дугаар сарын 25

№ 18/А0160058
САГ-2021/42/СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсролын үнэлгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд нийт 107 мэдээлэл оруулахаас хугацаа хоцроосон 24 байршуулаагүй 2 мэдээлэл, 27,276.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон албан томилолтын зарцуулалттай холбоотой 2 ажил гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын үнэлгээний ажлын албаны дарга Ж.Ган-Эрдэнэ, нягтлан бодогч Н.Шинэбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ
Ч.ДАШДАВАА

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of numerous horizontal rows, each defined by two parallel dotted lines. The rows are evenly spaced and extend across the entire width of the page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.